



103

**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 12 сарын 17 өдөр

Дугаар A/128

Ховд

**Ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагаа
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, "Төсвийн тухай" Монгол Улсын хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.1-д заасны дагуу 2020 оны жилийн үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр хамгийн өндөр оноо авч "Улсын тэргүүний аймаг"-аар шалгарч, батламж, 20.0 сая төгрөг бүхий мөнгөн урамшууллаар шагнагдсаныг тохиолдуулан харьяа агентлаг, байгууллагуудад баяр хүргэж, алдаршуулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор ёслол хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, зарцуулах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тус арга хэмжээний зохион байгуулалтыг сайтар хангаж, үйл ажиллагааг тайлагнан ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга /Д.Ариунбилэг/-д үүрэг болгосугай.

3. Зарцуулах хөрөнгийг 2020 оны "Шилдэг аймаг"-аар шалгарсан урамшууллын 20 000 000 төгрөг /хорин сая/-өөс зарцуулахыг ахлах нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

02 1129
D/Tush-A/128-Bo

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын
2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн
А/128 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

ЁСЛОЛ ХҮНДЭТГЭЛИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Зорилго:

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 11 дүгээр зүйлийн 11.1-д заасны дагуу 2020 оны жилийн үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр хамгийн өндөр оноо авч “Улсын тэргүүний аймаг”-аар шалгарч, батламж, 20,0 сая төгрөг бүхий мөнгөн урамшууллаар шагнагдсаныг тохиолдуулан харьяа агентлаг, байгууллагуудад баяр хүргэж, алдаршуулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх

Хоёр. Хугацаа:

2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын хуралдааны Их танхимд болно.

Гурав. Хамрах хүрээ:

Аймгийн Засаг даргын Тамгын газар болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, Зэвсэгт хүчний 123 дугаар анги, салбарууд, 17 сумын Засаг даргын Тамгын газар

Дөрөв. Хамтран ажиллах байгууллага:

Аймгийн Хөгжимт драмын театр

Тав: Зохион байгуулагч:

Аймгийн Засаг даргын Тамгын газар

Зургаа. Зохион байгуулалт:

1. Монгол Улсын хууль тогтоомж, төрийн бодлого, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагтаа амжилттай хэрэгжүүлэн 2020 оны нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээрээ тэргүүлсэн тул алдаршуулж, төрийн албан хаагчдыг идэвхжүүлэх нөлөөллийн арга хэмжээ болно.

2. Арга хэмжээнд аймгийн Засаг даргын Тамгын газар болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, Зэвсэгт хүчний 123 дугаар анги, салбарууд, 17 сумын Засаг даргын Тамгын газрын төлөөллүүдээс оролцуулна.

3.Тус хүндэтгэлийн арга хэмжээг төрийн байгууллагуудад дурсгалын зүйл, батламж олгож, ажлаараа тэргүүлсэн зарим төрийн албан хаагчдыг шагнаж, урамшуулахаар зохион байгуулна.

Долоо. Ёслолын үйл ажиллагааны төлөвлөгөө:

Д/Д	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
1	Арга хэмжээний хөтөлбөр боловсруулах	2021.12.15	ХШУДАХ-ийн дарга Д.Ариунбилэг
2	Засаг дарга, ЗДТГ-ын даргын мэдээлэл бэлтгэх	2021.11.16	Хэвлэл, мэдээллийн албаны дарга Х.Алтантуяа
3	Тайзны засал,хуралдааны танхим бэлтгэх, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх /ковид-19/	2021.12.20	ТЗУХ-ийн дарга Б.Ганболд
4	Хүндэтгэлийн үйл ажиллагаанд зориулсан тоглолтын хөтөлбөр гаргах	2021.12.17	ХДТ-ын дарга С.Ариунжаргал
5	Албан байгууллагууд руу шагнагдах албан хаагчдын нэр ирүүлэх тухай албан тоот хүргүүлэх	2021.12.16	ТЗУХ-ийн дарга Б.Ганболд
6	Шагнал бэлэн болгох: -Талархал –/сум, байгууллага -72ш/ -ЗД-ын өргөмжлөл-/байгууллага тус бүр 1ш/	2021.12.16	ХШУДАХ-ийн дарга Д.Ариунбилэг
7	Анонс бэлтгэх (цахим дэлгэцээр)	2021.12.16	ТЗУХ, Д.Дөмөгтүшиг
8	2020 оны онцлог үйл ажиллагааны тайланг дэлгэцээр цацахад бэлэн болгох	2021.12.16	ТЗУХ, Д.Дөмөгтүшиг

Найм. Ёслолын үйл ажиллагааны хөтөлбөр:

Д/Д	Арга хэмжээ	Цаг	Хариуцах эзэн
1. Бүртгэл: Ковид-19 ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ /маск тараах /			
1	2020 оны онцлог үйл ажиллагааны тайланг бэлтгэж, дэлгэцээр цацах /шторк/	15:00-15:10	ТЗУХ, Д.Дөмөгтүшиг
2. Цаг үеийн ажлын талаарх мэдээлэл			
2	Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав мэдээлэл хийнэ.	15:10-15:20	Хэвлэл, мэдээллийн албаны дарга Х.Алтантуяа
3	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Г.Пүрэвганди мэдээлэл хийнэ.	15:20-15:30	АИТХ-ын ажлын алба
3. Ёслол хүндэтгэлийн арга хэмжээ: Дэлгэц солигдоно /Ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд тохирсон 2020 оны өргөмжлөл, цомтой зураг оруулсан байна/			
4	“Тунгалаг буянт” дуу клиптэйгээ явна	15:30-15:35	ХДТ-ын дарга

5	Хүндэтгэлийн тоглолт /Алтангадас одонт ХДТ-ын уран бүтээлчид/	15:35-16:00	С.Ариунжаргал
	ХДТ-ын хөтлөгч: Аймгийн ЗДТГ-ын дарга Д. Энхболд даргыг урих/ /Энэ үед дэлгэцэн дээр шагнал гардаж авч буй зураг гарна/	16:00-16:10	Энэ үед дэлгэцэн дээр шагнал гардаж авч буй зураг гарна.
6	Шагнал гардуулах үйл ажиллагаа ✓ Засаг дарга, Хурлын дарга нарт хүндэтгэл үзүүлнэ. ✓ Албан байгууллагын хүндэт өргөмжлөл-55 ✓ Аймгийн Засаг даргын өргөмжлөл	16:10-16:55	ТЗУХ-ын хэлтэс ХШҮДАХ-ийн хэлтэс
7	Хаалтын арга хэмжээ: ЗДТГ-ын дарга Д. Энхболд	16:55-17:00	П. Мандухай
8	Дурсгалын зураг татуулах үйл ажиллагаа		Х. Есенкельд


Ес. Үр дүн, үр нөлөө:

Монгол Улсын хууль тогтоомж, төрийн бодлого, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх, төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй, шуурхай хүргэхэд төрийн байгууллага, албан хаагчдыг идэвхжүүлж, “Соёлтой төрийн үйлчилгээ-Авлига, хүнд сурталгүй аймаг” болох үйл явц дахь төрийн албан хаагчдын идэвх оролцоог нэмэгдүүлнэ.

--oOo--

107

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын
2021 оны 12 дугаар сарын 17 -ны өдрийн
А/128 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ЁСЛОЛ ХҮНДЭТГЭЛИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨСВИЙН ТООЦОО

Д/Д	Зардлын нэр төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Албан байгууллагын хүндэт өргөмжлөл	72	40,000	2.880.000
2	Дурсгалын зүйл /дэвтэр/	300	30.000	9.000.000
3	Дурсгалын зүйл /аяга/	150	6000	900.000
4	Дурсгалын зүйл /ИТХ-ын дарга, ЗД/	2	90.000	180.000
5	Засаг даргын өргөмжлөл	50	40.000	2.000.000
6	Театрын тоглолт	1	300.000	300.000
7	Маск, ариутгалын бодис	-	-	240.000
8	ЗДТГ-ын албан хаагчдын шагнал	-	-	2.500.000
9	Албан хаагчдын дархлаажуулалтын багц	-	-	2.000.000
Бүгд				20.000.000

-oOo-